

Холбооны Удирдах Зөвлөл дорвон жилийн хугацаагаар Их хурлаас сонгогдоно.

Удирдах зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдах ба гишүүдийн ердийн олонхи хүрэлцэн ирснээр хуралдаан хүчинтэйд тооцогдоно.

Удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба гишүүний бүрэн эрх нь холбооны үйл ажиллагаа явуулах хугацаанд хэрэгжинэ. Холбооны эрхэм зорилго, үйл ажиллагааны дүрмийг зовшоорсон гадаад орны иргэн Холбооны удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллаж болно.

Удирдах зөвлөлийн 6 гишүүн нь Холбооны их хурлын гишүүдээс сонгогдох ба эдгээр нь холбооны гишүүд байна. Удирдах зөвлөлийн 3 гишүүнийг оор байгууллагаас томилно.

Удирдах зөвлөлийн гишүүдийг гурван жил тутамд шинэчлэх бөгөөд 2 гишүүнийг жил бүр солих зарчим баримтална.

Холбооны жилийн ажлын тоолологоо, тайланг хэлэлцэн батална.

Хяналтын зөвлөлийн тайланг Удирдах зөвлөлийн хуралд танилцуулсны үндсэн дээр Их хуралд оруулах.

Удирдах Зөвлөлийн гишүүн хүндэтгэх шалтгааны улмаас Зөвлөлийн хуралд хүрэлцэн ирж оролцоогүй бол хурал эхлэхээс өмнө хэлэлцэх асуудлуудад огох саналаа бичгээр ирүүлж болно. Энэ тохиолдолд түүнийг хуралд ирсэнд тооцно.

Удирдах зөвлөлийн гишүүд (цаашид “гишүүн” гэх) аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байна. Удирдах зөвлөл нь хувь хүний асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хураах зарчмаар шийдвэрлэнэ. Удирдах зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэх асуудлаар гишүүн сонирхлын зорчилтэй байвал тухайн гишүүн энэ тухайгаа тайлбарлаж санал хураалтанд оролцохгүй. Удирдах зөвлөлийн хуралдаан даргалагч сонирхлын зорчилтэй байвал хуралдааныг оор гишүүн даргална. Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэлд тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, баталсан шийдвэр, нууц санал хураалтыг тоогоор, ил санал хураалтыг нэрээр гаргасан дүн, сонирхлын зорчилтэй холбогдсон тайлбар, гарах шийдвэрийн талаар зарчмын оор саналтай гишүүний тайлбар зэргийг тэмдэглэнэ. Гишүүн тайлбараа бичгээр гаргана. Удирдах зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, түүнийг мөргөөр зохиосон ажлын талаар дараагийн хуралдаанд гишүүдэд танилцуулж байна.

Удирдах зөвлөл нь бодлогын чанартай шийдвэрийн эрсдэлийг хүлээнэ.

-
- **Холбооны удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирлын бүрэн эрх**
 - Удирдах зөвлөлийн дарга нь холбооны тэргүүн байна.
 - Удирдах зөвлөлийн дарга нь Холбоог гадаад, дотоодод тоолоох, Удирдах зөвлөлийн хуралдааныг даргална.
 - Удирдах зөвлөлийн дарга нь удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлын талаар Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулж ажиллана.
 - Гүйцэтгэх захирал 4 жилийн хугацаатай Удирдах Зөвлөлөөс сонгогдож

ажиллана.

- Гүйцэтгэх захирал нь оорийн бүрэн эрхийн хугацаа дууссан нохцолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл албан үүргээ хэвээр гүйцэтгэнэ.

Гүйцэтгэх захирал дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Холбооны одор тутмын вйл ажиллагааг удирдан зохион байгуулж, шийдвэрийн хэрэгжилтийг хангах.
- Холбооны жилийн толовлогоог Удирдах зоволоор батлуулж, түүний биелэлтийг тайлагнах;
- Холбооны вйл ажиллагааны талаар Их хуралд тайлагнах;
- Холбооны нэрийн омоос тор, засгийн байгууллагатай харилцах, холбоог толоолох.
- Холбооны зохион байгуулалт, орон тоо, цалингийн схем, сангуудын хэмжээ, шагнал урамшлын журмыг Удирдах зовлолтэй зовшилцон батлах ба холбооны менежер, ажилтны цалин, эрх, үүргийн хэм хэмжээг тогтоох
- Удирдах зоволоос олгосон бүрэн эрхийн хүрээнд Холбооны нэрийн омоос гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй харилцах, гэрээ хэлцэл хийх, шvvх, арбитрт нэхэмжлэгч, хариуцагчаар итгэмжлэлгvй оролцох;
- Эрх хэмжээний асуудлаар тушаал гаргах;
- Хууль, гэрээнд заасан бусад бүрэн эрх

{slide=Хурлын тэмдэглэл 090402} {pdf}images/pdfbook/hurliintemdegel/090402 MSRM's board meeting.pdf{/pdf} {/slide}

{slide=Хурлын тэмдэглэл 100107}{pdf}images/pdfbook/hurliintemdegel/100107 MSRM's board meeting.pdf{/pdf}{/slide}

{slide=Хурлын тэмдэглэл 100315}{pdf}images/pdfbook/hurliintemdegel/100315_MSRM's Board Meeting.pdf{/pdf}{/slide}